




**“ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ДЭЛХИЙН ӨДӨР”-Т**

ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бидний алсын хараа

Дэлхийн хаана ч, ямар ч цаг үед үйлчлүүлэгч бүр аюулгүй, эрсдэл хор хохиролгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авдаг байх.

Бидний эрхэм зорилго

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах, түүнд учрах хор хохирлыг бууруулахын тулд эрсдэлийг удирдахад дэмжлэг үзүүлэх.

Бидний хандлага

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх ажил 2004 онд өвчтөний аюулгүй байдлыг хангах Дэлхийн холбоо байгуулснаар эхэлсэн бөгөөд улмаар ДЭМБ дэлхий даяар үйлчлүүлэгчид хор уршиг учруулахаас сэргийлэхийн тулд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийн удирдлага, өвчтөний аюулгүй байдлыг сайжруулж, зохицуулах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын нэгж бий болгосон. 2002 оноос хойш, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах талаарх дэлхийн болон бүс нутгийн тогтоолууд дараалан батлагдан гарав. ДЭМБ нь манлайллыг бий болгох, тэргүүлэх чиглэлийг тогтоох, мэргэжилтнүүдийг бэлтгэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, сүлжээг бий болгох, удирдамж гаргах,

"Энэхүү дээд хэмжээний үүлзалт нь хэн ч үл тоомсорлож болох өвчтөний аюулгүй байдлыг хангах чухал асуудлыг шийдвэрлэх хөдөлгөөнийг улам идэвхжүүлнэ гэдэгт би бүрэн итгэлтэй байна".

Бонн хотод болсон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх дэлхийн улс орнуудын сайд нарын II дээд хэмжээний үүлзалт. ДЭМБ-ын Ерөнхий захирал Др. Маргарет Чан, 2017 оны 3-р сар

өөрчлөлтийг бий болгох, чадавхийг бий болгох, хяналт шинжилгээ хийх замаар дэлхий даяар өвчтөний аюулгүй байдлын хөтөлбөрийг боловсруулахад анхаарч байна. Мөн үйлчлүүлэгч төвтэй найдвартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тулд ДЭМБ-аас үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын сайжруулах стратегийн дараах гол чиглэлүүдийг баримтлан ажиллаж байна.

- Дэлхий нийтийн манлайлал, хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Гарын авлага, аргачлал боловсруулах, чадавхыг бий болгох
- Үйлчлүүлэгч болон гэр бүлүүдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцуулах
- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулахад хяналт тавих¹.

¹ Patient Safety, Making health care safer, 2017

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах бидний арга барил



Хүлээгдэж буй үр дүн

- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал сайжирна.
- Эрсдэл, хор хохирол буурна.
- Эрүүл мэндийн үзүүлэлт сайжирна.
- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж сайжирна.
- Зардал буурна

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ТОКИОГИЙН ТУНХАГЛАЛ

Дэлхийн улс орнуудын сайд нарын III дээд хэмжээний уулзалт, 2018 оны 4-р сарын 14, Токио хот, Тунхаглалыг дэвшүүлсэн: Япон, Герман, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

Зөвшөөрөн баталсан: Япон, Австрали, Бруней Даруссалам, Хорват, Чех, Дани, Финланд, Франц, Грек, Индонези, Литва, Люксембург, Монгол, Оман, Польш, Катар, Өмнөд Африк, Словак, Шри Ланка, Швейцарь, Вьетнам, Азийн хөгжлийн банкны институт, Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Дэлхийн банкны групп, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төлөөх хөдөлгөөний сан, Дэлхийн анагаах ухааны нийгэмлэг)

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх Токиогийн Тунхаглал нь Дэлхийн Эрүүл Мэндийн Ассемблейн 55.18 дахь (2002 он) шийдвэрт тусгагдсан бодлогууд дээр тулгуурлан гарсан бөгөөд “үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад нэн тэргүүнд анхаарах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад шаардлагатай шинжлэх ухааны үндэслэлтэй тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэхийг гишүүн орнуудад уриалсан. Дэлхийн улс орнуудын сайд нарын дээд хэмжээний тус уулзалтад дэлхийн 44 улсын ЭМЯ-ны төлөөлөгчид, засгийн газрын өндөр түвшний 500 орчим оролцогчид, дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудын төлөөлөл оролцож үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлын талаарх асуудлаар 2018 оны 4-р сарын 13-аас 14-ний өдрүүдэд Япон улсын Токио хотод чуулсан юм. Япон улсын Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Халамжийн Яам, Герман, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, ДЭМБ-аас техникийн дэмжлэг үзүүлсэн.

Дээд хэмжээний цуврал уулзалтыг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман улс үүсгэн санаачилжээ.

Бид амлалтаа бататгахын тулд хэн болох, хаана амьдардагаас үл хамааран бүхий л иргэд үйлчлүүлэгчдийн хувьд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах явцад нь учирч болох аливаа хохирол, эрсдэлийг 2030 он хүртэл шат дараатайгаар бууруулах замаар үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн Токиогийн Тунхаглалыг баталж байна. Үүнд:

Найдваргүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, зайлсхийх боломжтой ч өвчтөнд учирч буй хохирол нь дэлхий даяар эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгамдаж буй ноцтой сорилтууд болж байгааг тухайлбал; сэргийлэх боломжтой ч хүнд тохиолдож буй хор үршиг тодорхой түвшинд байсаар байгаа, эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилт хүндрэлтэй, эрүүл мэндийн тогтолцоо болон засгийн газарт итгэх итгэл алдагдаж байгаа зэргийг бүгдийг хүлээн зөвшөөрөх; Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг дэмжих, хэрэгжүүлэх хэрэгцээ

шаардлага нь эрүүл мэндийн тогтолцоо, тусламж үйлчилгээний бүхий л түвшинд, эрүүл мэндийн бүхий л байгууллагад тавигдах үндсэн шаардлага гэж хүлээн зөвшөөрөх;



Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал гэдэг нь бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын хамгийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг бөгөөд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs) руу шилжих; үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын тогтолцоо, түршлагыг бүх улс оронд бий болгож улмаар бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг тогтвортой байлгахад чиглэсэн эрүүл мэндийн нэн чухал стандартуудын нэг болгох нь зүйтэй;

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах явдал нь дэлхий даяар яаралтай болон амбулаторийн тусламж үйлчилгээнд тухайлбал эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, хамт олон болон өрх гэр бүлд суурилсан цогц тусламж үйлчилгээнд шаардлагатай байгаа ба энэ нь эрүүл мэндийн сайн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн нэгдмэл, хүн төвтэй тусламж үйлчилгээ байх нь зүйтэй;

Ахмад настны эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх л түвшинд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган насжилтын нийгмийн өвөрмөц хэрэгцээ болон онцгой эмзэг байдлыг хүлээн зөвшөөрөх;

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн гүйцэтгэх үүргийг мэдээлэл цуглуулах, тандалт судалгаа хийхээс эхлээд хяналт дүн шинжилгээ хийх, анхааруулга өгөх хүртэлх болон эрсдэлийг

урьдчилан тооцоолох, тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлыг сайжруулах зэрэг үйл явцад гүйцэтгэх үүргийг тодотгох;

Эрүүл мэндийн тогтолцоо улс орон бүрт ялгаатай боловч үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд заналхийлсэн олонхи тохиолдол нь ижил төстэй шалтгаануудтай, ихэнхи нь ижил шийдлүүдтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх; Ингэснээр үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдлын мэдээллийг бусадтай хуваалцах, түүнээс суралцах, аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг хангахад чиглэсэн улс орон, институт хоорондын хамтын ажиллагааны хэрэгцээ байгааг харуулж байна;

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүхий л шатлал, түүний дотор анхан шатны тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хянах хэмжих хүчирхэг тогтолцооны ач холбогдлыг онцлох;

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэргэжилтнүүдэд мэргэжлийн боловсрол, ил тод байдал, тасралтгүй сургалтын ач холбогдлыг ойлгуулах, аюулгүй найдвартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадварлаг, энэрэнгүй мэргэжлийн боловсон хүчнийг хөгжүүлэхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж байна. Эрүүл мэндийн ажилтнууд аюулгүй найдвартай эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд шаардлагатай хөдөлмөрийн зохистой орчинг бүрдүүлэхэд анхаарах;

Аюулгүй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд тухайлбал бодлого боловсруулах, зохион байгуулалтын түвшин, шийдвэр гаргах, эрүүл мэндийн чиглэлээр мэдлэг олгох, өөрийгөө арчлах гэх мэт ер нь тусламж үйлчилгээтэй холбоотой бүхий л асуудалд өвчтөн, тэдгээрийн ар гэрийнхний үүрэг оролцоо, эрх мэдлийг хангах;

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад гарсан ахиц дэвшил хэтэрхий удаан байдаг талаар бид санаа зовж, улс орон бүрийн хүчин чармайлтыг үл харгалзан, бид дэлхийн хэмжээнд өвчтөний аюулгүй байдлыг дээшлүүлэхийн тулд ахиц дэвшлийг хурдасгахын төлөө илүү их амлалт авахыг уриалж байна. Бид дараах зүйлсийг тунхаглаж байна: Дэлхийн улс орнуудад "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаархи дэлхий нийтийн үйл ажиллагаа"

сэдэвт улс төрийн эрч хүчийг өндөр түвшинд байлгах, бага болон дунд орлоготой улс орнуудтай нягт хамтран ажиллах, суралцах замаар чадавхийг бэхжүүлэх; эрүүл мэндийн салбарын бодлого, хөтөлбөрүүдэд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг эрэмбэлэх, бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад чиглэсэн хүчин чармайлтаа нэмэгдүүлэх;

Нийтийн болон хувийн аль ч эрүүл мэндийн тусламжийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, анхан шатны тусламжийн түвшингээс лавлагаа тусламжийн түвшинд хүртэл өвчтөний аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн тогтолцооны өөрчлөлтийг хэрэгжүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн хамралт болон тогтвортой байдлын зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах; Үйлчлүүлэгч төвтэй тусламж дэмжлэг үзүүлэх манлайлал, удирдлагын чадавхийг дээшлүүлэх, өвчтөний аюулгүй байдлын тогтолцоог хэрэгжүүлэх, үйл явцыг бэхжүүлэх, аюулгүй байдал, урамшууллын ил тод байдлын соёлыг бий болгох, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад эрүүл мэндийн

ажилтнуудыг сургах, боловсрол эзэмшүүлэх үүнд үйлчлүүлэгчийн ар гэрийг татан оролцуулах, эрсдэлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэн хор үршгийг багасгах, шилдэг туршлагауд ба амжилттай загваруудаа хуваалцах замаар үр ашгийг нэмэгдүүлэх;

Тунхаглалд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад улс төрийн өндөр түвшний дэмжлэг, эрмэлзлийг хадгалж, дэлхийн улс орнууд, үүн дотроо бага болон дунд орлоготой улсуудад чадавхи бэхжүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад гаргаж буй хүчин чармайлтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн салбарын бодлого, хөтөлбөрүүдэд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын асуудлыг

тэргүүлэх чиглэлүүдийн нэг болгох, улсын болон хувийн салбарын эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжих, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг дэмжих, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэхэд удирдлага манлайллын чадавхийг сайжруулах болон жил бүрийн 9 дүгээр сарын 17-ны өдрийг Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлж байхыг тунхаглаж байна.



ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ГАРГАСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХИ 10 БАРИМТ²

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал нь дэлхийн дахинаа нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж байна. Нисэх онгоцоор яваа гурван сая зорчигчдод хор үршиг учруулж болзошгүй нэг тохиолдол гардаг бол эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах явцад гурван зуун тохиолдолд нэг хор үршиг учирдаг гэж үздэг. Энэ нь нисэх онгоц, цөмийн үйлдвэрлэл зэрэг өндөр эрсдэлтэй үйлдвэрүүдийн аюулгүй ажиллагааны бүртгэл нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнийхээс илүү сайн байдгийг харуулж байгаа юм.

Баримт 1: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах үед үйлчлүүлэгчид тохиолддог хор үршиг нь дэлхий дахины өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болсон сүрьеэ, хумхаатай харьцуулахад 14-р байранд ордог.



² https://www.who.int/features/factfiles/patient_safety/en/

Дэлхийн түвшинд жилд 421 сая хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа бөгөөд тэднийг эмнэлэгт хэвтэх үед тусламж үйлчилгээтэй холбоотой 42 сая орчим таагүй тохиолдол гардаг байна.

Баримт 2: Эмнэлэгт хэвтэж байгаа 10 эмчлүүлэгч тутмын нэг нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой асуудалд өртдөг.

Өндөр хөгжилтэй оронд 10 үйлчлүүлэгч тутмын 1 ба түүнээс илүү тохиолдол нь эмнэлгийн тусламж авч байх үедээ хохирдог гэсэн судалгаа байдаг. Эдгээр төрөл бүрийн тохиолдол, таагүй үйл явдлын 50 орчим хувь нь урьдчилан сэргийлэх боломжтой байдаг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой гарч буй таагүй үйл явдлын давтамж, түүнээс урьдчилан сэргийлэлтийн талаар дунд болон бүүрай хөгжилтэй 26 оронд хийсэн судалгаагаар таагүй үйл явдлын түвшин (сөрөг үйл явдал) 8% байсан байна. Үүний 83% нь урьдчилан сэргийлэх боломжтой байсан бөгөөд 30% нь үхэлд хүргэжээ. Бүх таагүй (сөрөг үйл явдал) үйл явдлын ойролцоогоор гуравны хоёр нь бага болон дунд орлоготой орнуудад тохиолдож байна.

Баримт 3 : Эмийн зохисгүй хэрэглээ нь сая сая хүнд хор уршиг учруулж жил бүр хэдэн тэрбум долларын зардал гаргадаг.

Эмчилгээний бүрүү дадал, алдаа нь дэлхийн түвшинд эрүүл мэндийн тогтолцоонд байж боломгүй буюу зайлсхийж болох хор уршгийн гол шалтгаан болж байна. Цалин, хөдөлмөрийн бүтээмж, эрүүл мэндийн зардлыг тооцолгүйгээр эмчилгээний алдаатай холбоотой зардалд дэлхий даяар жил бүр 42 тэрбум ам.доллар зарцуулж байна. Энэ нь дэлхий дахины эрүүл мэндэд зарцуулж байгаа нийт зардлын бараг 1%-ийг эзэлдэг. Эмчилгээний алдаа нь эмнэл зүйн тусламж, үйлчилгээний тогтолцоо сул нөхцөлд тохиолддог. Мөн хүний хүчин зүйлс тухайлбал ажлын хэт ачаалал, ажлын

байрны тааруу нөхцөл, тогтворгүй байдал, хүний нөөцийн дутагдал зэрэг нь эмийн жор бичилт, бүртгэлт, түгээлт, удирдлага, хяналт-шинжилгээний үйл ажиллагаанд нөлөөлдөг ба хүнд хор уршиг учруулах, хөгжлийн бэрхшээл, тэр ч байтугай үхэлд хүргэж болдог байна.

Баримт 4: Эрүүл мэндийн зардлын 15 хувь нь тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой гарах таагүй (сөрөг) тохиолдлыг шийдэхэд зарцуулагддаг.

Сүүлийн үеийн судалгаагаар ЭЗХАБ-ын улс орнуудын эмнэлгийн үйл ажиллагааны зардлын 15% нь венийн тромбоэмболизм, шархны халдвар зэрэг тусламж үйлчилгээний таагүй үйл явдалд зарцуулагддаг болох нь тогтоогджээ. Эдгээр улс орнуудад эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой хор уршигийн нийт зардалд жилд дунджаар хэдэн триллион доллар зарцуулсан байна.

Баримт 5: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх таагүй тохиолдлыг бууруулахад хөрөнгө оруулалт хийх нь санхүүгийн ихээхэн хэмнэлт гаргахад хүргэнэ.

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх таагүй тохиолдлыг бууруулахад хөрөнгө оруулалт хийх нь үйлчлүүлэгчид тохиолдох сөрөг үр дагаварыг бууруулахаас гадна санхүүгийн ихээхэн хэмнэлт гаргадаг. АНУ-д 2010-2015 онд “Medicare” эмнэлгүүдэд тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг сайжруулахад анхааран ажилласны дүнд 28 тэрбум ам.долларын хэмнэлт гаргасан байна.

Баримт 6: Эмнэлгээс шалтгаалах халдварт 100 үйлчлүүлэгч тутмын 14 нь өртдөг болохыг хүлээн зөвшөөрсөн.

Өндөр хөгжилтэй орнуудад хэвтэж эмчлүүлсэн 100 үйлчлүүлэгчийн тутмын 7, буурай болон дунд хөгжилтэй орнуудад 10 нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар авдаг бөгөөд жил бүр хэдэн зуун сая эмчлүүлэгчид халдварт өртөж байна. Европын холбооны орнуудад жил бүр 3.2 сая өвчтөн эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварт өртдөг бөгөөд тэдний 37,000 орчим нь нас баржээ. Энгийн, хямд өртөгтэй тухайлбал,



гар угаалт зэрэг халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг авснаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын давтамжийг 50-иас дээш хувиар бууруулж болдог байна.

Баримт 7: Жил бүр нэг сая гаруй өвчтөн мэс заслын хүндрэлээс болж нас барж байна.

ДЭМБ-ын судалгаагаар дэлхийн хэмжээнд мэс заслын улмаас өвчлөл, нас баралтын түвшин өндөр хэвээр байгаа бөгөөд жилд наад зах нь 7 сая хүн мэс заслын хүндрэлээс тахир дутуу болж үүнээс 1 сая гаруй хүн нас бардаг байна. Сүүлийн 50 жилд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн олон төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэний дүнд мэс засал, мэдээгүйжүүлэлттэй холбоотой нас баралт тасралтгүй буурсан ч, буурай дунд хөгжилтэй орнуудад өндөр хөгжилтэй орнуудаас хоёроос гурав дахин өндөр хэвээр байна.

Баримт 8: Буруу эсвэл хожуу оношлогоо нь

тусламж үйлчилгээний бүх түвшинд нөлөөлж олон тооны эмчлүүлэгчид хүлээн зөвшөөрөх боломжгүй хор уршиг учруулдаг.

Судалгаагаар АНУ-д насанд хүрэгчдийн тав орчим хувь нь жил бүр амбулаториар үйлчлүүлэх үедээ оношилгооны алдаанд өртдөг байна. Цогцост хийсэн задлан шинжилгээний судалгаагаар АНУ-д нас барагсдын 10 орчим хувь нь оношлогооны алдаанд өртдөг болохыг тодорхойлсон байна. Малайз улсад хийсэн судалгаагаар анхан шатны тусламж үйлчилгээний эмнэлгүүдэд оношилгооны алдааны тархалтын түвшин 3.6% байжээ. Эмнэлгийн бүртгэлд хийсэн судалгаагаар оношилгооны алдаанууд бүх сөрөг тохиолдлын 6-17%-ийг эзэлж байна.

Буурай, дунд хөгжилтэй орнуудад нотолгоо хязгаарлагдмал мөн оношлогооны үйл явцад нөлөөлөх хүчин зүйлүүд тухайлбал; тусламж үйлчилгээ, оношлогооны багаж хэрэгслийн хүрээлцээ хязгаарлагдмал, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтнүүд хангалтгүй, цаасан дээр суурилсан бүртгэлийн тогтолцоо зэргээс шалтгаалан оношлогооны алдаа ба түүний сөрөг үр дагаврын түвшин өндөр байх магадлалтай байна.

Баримт 9: Туяаны хэрэглээ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж, байгаа хэдий ч хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл нь аюулгүй байдлын чухал асуудал юм.

Ионжуулах туяа нь хүн амыг цацрагийн нөлөөнд өртүүлэх хамгийн том эх үүсвэр юм. Дэлхий даяар жил бүр 3.6 тэрбум рентген шинжилгээ хийдэг бөгөөд тэдний 10 орчим хувь нь хүүхдүүдэд хийгддэг. Мөн жил бүр 37 сая гаруй цөмийн эмчилгээ, 7,5 сая туяа эмчилгээ хийгддэг. Шаардлагагүй эсвэл мэргэжлийн бус эмчилгээний цацраг идэвхит бодисын хэрэглээ нь өвчтөн болон эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй.



Баримт 10: Анхан шатны тусламж үйлчилгээтэй холбоотой эмнэлгийн алдааны тал хувийг удирдлагын үйл ажиллагааны алдаа эзэлдэг.

Саяхны тойм судалгаагаар анхан шатны тусламж үйлчилгээний түвшинд 100,000 өвчтөнг үзэж, зөвлөгөө тутамд 5-80 удаагийн эмнэлгийн алдаа тохиолддог гэж үзжээ. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд хамгийн түгээмэл тохиолддог алдаанууд нь үйлчилгээ үзүүлдэг тогтолцоо, үйл явцтай холбоотой үйл ажиллагааны алдаа байдаг. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн бүх алдааны 5-50% нь үйл ажиллагааны удирдлагын алдаанаас болж байна гэж тооцоолсон байна.

Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн бүх алдааны 5-50% нь удирдлагын алдаанаас болж байна гэж тооцоолсон байна.³

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗОРИЛТУУД

Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах

1

Үр дүнтэй харилцааг хөгжүүлэх

2

Өндөр сэрэмжүүлэг бүхий эмийн аюулгүй байдлыг сайжруулах

3

Мэс засал, мэс ажилбарын аюулгүй байдлыг сайжруулах

4

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг бууруулах

5

Эмнэлгийн нөхцөлд унаж бэртэхээс сэргийлэх

6

³ https://www.who.int/features/factfiles/patient_safety/en/